



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 4/439

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.3, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2, 30.3.3 дахь заалт, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын эхний 100 хоногт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гэр бүлд суурилсан нийгмийн үйлчилгээг хүн амын бүлгүүдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлж, тэгш хүртээмжтэй, чанартай, хүний эрхэд тулгуурлан цогцоор үзүүлэх "Гэр бүлийн хөгжлийн цогц төв"-ийг Хөвсгөл аймагт байгуулах ажлын бэлтгэл, зохион байгуулалт хариуцах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох яам, газар, албан тушаалтнуудтай мэдээлэл шуурхай солилцож, төв байгуулах байшин, барилга оффисын боломж нөхцөлийг судлан, аймгийн хүүхэд, гэр бүл, хүн амын бүлгүүдийн аж байдалд шинжилгээ- үнэлгээ хийн, түүнд тулгуурлан уг төвөөр үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн менежмент, хүний нөөц, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналт, үнэлгээг тодорхойлон, үр дүнг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 03-ны өдрийн 2/439
дугаар захирамжийн хавсралт

“ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ ТӨВ”-ИЙГ ХӨВСГӨЛ АЙМАГТ
БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр 1)
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
- Аймгийн Боловсролын газрын дарга
- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
- Аймгийн Соёл, урлагийн газрын дарга
- Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
- Хөвсгөл аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга
- Мөрөн сумын Засаг даргын орлогч
- Аймгийн Ахмадын хорооны дарга
- Мөрөн сумын Насан туршийн боловсролын төвийн захирал
- Аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн гүйцэтгэх захирал
- Төрийн бус байгууллагын төлөөлөл (зөвшилцсөнөөр 2)

Нарийн бичгийн дарга:

-Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

оОо